



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**

**“ МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ ” ТӨХК**

**2023 ОНЫ I УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСАНД  
ХИЙСЭН ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН  
[Ажлын баримт: 3002-1 ]**

**УЛААНБААТАР ХОТ**

**2023.05**

## 1. Аудитын зорилго ба цар хүрээ

**Зорилго:** Компанийн хэмжээнд шилэн данс хөтлөлтийн үйл ажиллагааг хуулийн дагуу үнэн зөв зохион байгуулсан эсэх, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, нээлттэй, ил тод, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих зорилгоор цахим сүлжээнд байршуулж байгаа мэдээллийн үнэн зөвд дотоод аудитын баталгаа өгөхөд оршино.

### ➤ Аудитын цар хүрээ

- 2023 оны 1-3 дугаар саруудын харилцахын баримтаас шилэн дансанд мэдээлэх чиг үүргийн холбогдолтой гүйлгээг түүвэрлэж, үнэн зөв, бүрэн мэдээлсэн эсэхийг шалгах
- Тайлант хугацаанд шилэн дансанд байршуулсан мэдээллүүдийг татаж авч хүснэгтэд нэгтгэх
- Байршуулбал зохих мэдээллүүдийг байршуулсан мэдээллүүдтэй тулгалт хийж аудитын нотолгоо бэлтгэх
- Тайлан бэлтгэж дүгнэлт, зөвлөмж өгөх
- Дээрх эрх зүйн баримт бичгийн хүрээнд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

➤ **Аудитын объект нэгж:** Захиргаа, удирдлагын газар, Санхүү эдийн засгийн газар

➤ **Аудитын төрөл:** Дотоод аудитын тайлан

➤ **Хамрах хугацаа:** 2023 оны 1-р улирал

**“МТЗ” ТӨХК-ийн 2023 ОНЫ I УЛИРЛЫН ШИЛЭН ДАНСНЫ МЭДЭЭЛЭЛ**

2023 оны I-р улирал

№	Шилэн дансны мэдээллийн төрлийн нэр	Мэдээлэл оруулах давтамж	Нийт мэдээлэх	Хугацаандаа мэдээлсэн	Хугацаа хоцроож мэдээлсэн	Мэдээлэл байршуулаагүй /хугацаа болоогүй/
1	Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт	Сар бүр	3	3	0	0
2	Санхүүгийн тайлан /гүйцэтгэл/	Хагас жил, бүтэн жил	2	0	0	2
3	Хандив тусламжийн зарцуулалтын тайлан/ гүйцэтгэл/	Хагас жил, бүтэн жил	2	0	0	2
4	Хандив тусламжийн орлого /гүйцэтгэл/	Хагас жил, бүтэн жил	2	0	0	2
5	Дараа жилийн зорилтот түвшин /төлөвлөгөө/	Жил бүр	1	0	0	1
6	Байгууллагын батлагдсан төсөв /төлөвлөгөө/	Хагас жил, бүтэн жил	1	1	0	0
7	Төрийн өмчийн ААН байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт /төлөвлөгөө/	Бүтэн жил, хагас жил, улирал бүр, сар бүр	1	1	0	0
8	Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт /гүйцэтгэл/	Жил бүр	1	0	0	1
9	Тухайн жилийн зорилтот түвшинд орсон нэмэлт өөрчлөлт	Тухай бүр	3	3	0	0
10	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ	Тухай бүр	3	3	0	0
11	Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ	Тухай бүр	3	3	0	0
12	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт /гүйцэтгэл/	Сар бүр	3	3	0	0

13	Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт / төлөвлөгөө/	Жил бүр	1	1	0	0
14	Худалдан авах ажиллагааны тайлан /гүйцэтгэл/	Жил бүр	1	0	0	1
15	Худалдан авах ажиллагааны тайлан /төлөвлөгөө/	Жил бүр	1	0	1	0
16	Хөрөнгийн болон урсгал зардал тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл	Тухай бүр	3	3	0	0
17	Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан /гүйцэтгэл/	Жил бүр	1	0	0	1
18	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8,9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл	Тухай бүр	3	3	0	0
19	Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр	Тухай бүр	3	3	0	0
20	Тухайн байгууллагын хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээнд орсон өөрчлөлт	Тухай бүр	3	3	0	0
21	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн	Тухай бүр	3	3	0	0
22	Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл	Тухай бүр	3	3	0	0
23	Байгууллагын орон тоонд гарсан өөрчлөлт	Тухай бүр	3	3	0	0
	<b>Нийт</b>		<b>50</b>	<b>39</b>	<b>1</b>	<b>10</b>

## 2. ДҮГНЭЛТ

1. Байгууллагын батлагдсан төсвийг хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн оруулсан байна.
2. 2023 оны I улиралд жилийн эхнээс өссөн дүнгээр нийт 50 мэдээ оруулахаас хугацаандаа оруулсан 39 мэдээ, мэдээлэл байршуулах хугацаа болоогүй 10 мэдээ, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.
3. Компанийн 5 дансны орлогын 32 гүйлгээ, зарлагын 118 гүйлгээ нийт 2023 оны 1-р улиралд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого болон зарлагын 150 мөнгөн гүйлгээг бүрэн оруулж мэдээлсэн байна.
4. Шилэн дансны тухай хуулийн 6.1.6-т /төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр тогтмол мэдээлнэ/ гэсэн заалтын дагуу төсвийн гүйцэтгэлийг мэдээлэхдээ хэмнэсэн болон хэтэрсэн тайлбарын шалтгааныг оруулаагүй байна.
5. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийн үнэн зөв байдалд хяналт тавьж тушаал шийдвэрийг үндэслэн үнэн бодит мэдээлэл оруулахад анхаарах
6. ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хүрээнд худалдан авах бараа ажил үйлчилгээний зарлагдсан тендерийн мэдээлэл, оролцож шалгарсан байгууллагын талаарх тодорхой мэдээлэлгүй байна.

### 3. ЗӨВЛӨМЖ

1. Компанийн зорилтот түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийн харьцуулалтын хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг оруулахыг Санхүү, эдийн засгийн албаны эдийн засагчид
2. Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлтийн мэдээллийг тушаал шийдвэрийг үндэслэн үнэн зөв оруулж байхыг Хүний нөөцийн албаны мэргэжилтэнд
3. ТБОНӨХБАҮХАТухай хуулийн хүрээнд худалдан авах бараа ажил үйлчилгээний зарлагдсан тендерийн мэдээлэл, оролцож шалгарсан байгууллагын талаарх мэдээллийг tender.gov.mn хуудсанд зарлагдсан тендерийн мэдээллийн хүрээнд оруулж байхыг Худалдан авалт, хангамжийн албаны мэргэжилтэнд
4. Шилэн дансны мэдээлэл байршуулахад  
Захиргаа удирдлагын газар – Худалдан авалт, хангамжийн алба  
- Хүний нөөцийн алба  
Санхүү, эдийн засгийн газар – Нягтлан бодох бүртгэлийн газар  
- Эдийн засгийн алба  
Дээрх Газрын ахлах менежерүүд, албаны Менежер шилэн дансанд оруулж байгаа мэдээлэлд хяналт тавьж баталгаажуулж байхыг тус тус хэрэгжүүлж ажиллах.

ТАНИЛЦСАН:

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П. ГАНХҮҮ

ХЯНАСАН:

ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ МЕНЕЖЕР

A handwritten signature in black ink, appearing to be "Б. Лхагвасүрэн".

Б. ЛХАГВАСҮРЭН

ДҮГНЭЛТ БИЧСЭН:

ДОТООД АУДИТЫН МЭРГЭЖИЛТЭН

A handwritten signature in black ink, appearing to be "Л. Туул".

Л.ТУУЛ